



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай

Сүүлийн 5 жил улсын хэмжээнд үер, усны ослоор 800 орчим хүн амь насаа алдсанаас 20 орчим хувь нь хүүхэд байна. Үүний шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд иргэд амралт зугаалгаар явахдаа архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн, бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сулруулсан, баталгаагүй зам, гарц гарамгүй хэсгээр болон үертэй үед гол гаталсан гэх шалтгаанууд голлож байна.

Мөн нийт нутгийн 70 гаруй хувьд 3-10 см гаруй, гуу жалга газраар 30-120 см орчим цасан бүрхүүл тогтож, төв суурин газруудад гол, горхины халиа тошин ихээр үүсч байгаа бөгөөд 2024 оны эхний 3 сарын хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас ахиу, агаарын температур олон жилийн дунджаас 3-5 хэмээр дулаан байхаар байна. Энэхүү нөхцөл байдал нь 2024 оны хавар үер усны аюул болж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй төлөв байдлыг бий болгож байна.

Иймд мэргэжлийн байгууллагуудаас гаргасан мэдээллийг иргэдэд өргөн цар хүрээтэй хүргэж, болзошгүй үер, усны гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг цаг алдалгүй эрчимжүүлж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн сайжруулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, нэн шаардлагатай зохион байгуулалт болон төсөв хөрөнгийг шийдвэрлэх чиглэлээр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.4 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын гишүүд, яам, агентлагийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт ДААЛГАХ НЬ:

Нэг. Барилга, хот байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэнд:

1.1. Үерийн далан, суваг, шуудууны төлөвлөлт, ашиглалтад хяналт тавьж, шаардлагатай газруудад засвар, сэргээн босголтын ажлыг цаг алдалгүй хийх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагууд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах,

1.2. Салбарын чиглэлээр бүхий л түвшинд бэлтгэл, бэлэн байдлаа хангаж, далан суваг, шуудууны хэвийн ашиглалтыг хангах, гарсан эвдрэл гэмтлийг засварлах, сэргээн босгох, харьяа байгууллагуудыг заавар, зөвлөмжөөр хангаж, хяналт шалгалтыг Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран тогтмол зохион байгуулж, шаардлагатай эд материал, хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх,

**Хоёр. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзоригт:**

2.1. Болзошгүй үерийн үед ажиллах эрүүл мэндийн байгууллагуудын хүн хүч, техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэх, салбарын бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгах бодис материалын нөөцийг бүрдүүлэх,

2.2. Үерийн дараа үүсч болзошгүй халдварт өвчний эрсдэлийн үнэлгээг хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх, ариутгал хадваргүйтгэлийг чанартай зохион байгуулах,

**Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Бямбацогтод:**

3.1. Болзошгүй үерийн улмаас эвдрэл гэмтэл үүсч болзошгүй авто зам, замын байгууламж, төмөр замын дагуу үерийн эрсдэлийн үнэлгээг хийж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, засвар үйлчилгээг төлөвлөгөөний дагуу чанартай хийж, бүх чиглэлд тээврийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх,

3.2. Үерийн улмаас эвдэрч, нурсан зам, гүүрийг богино хугацаанд сэргээн засварлахад шаардлагатай эд материал, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлж, хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг харьяа байгууллага, салбар нэгжүүдийн хэмжээнд хангуулах,

**Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэд:**

4.1. Усны урсац газар, голын гольдрол газруудад хяналт шалгалт хийж, тухайн газруудад иргэд суурьшсан эсэхийг тодруулж, үерийн эрсдэлийг тодорхойлох, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, эрсдэл бүхий газраас иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

**Тав. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Учралд:**

5.1. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран саадгүй шуурхай хүргэх бодлогын болон техникийн шийдлийг гаргах, хөгжүүлэх,

5.2. Эрт зарлан мэдээллийг системийг сайжруулах, хөгжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, болзошгүй үерийн гамшгийн үед харилцаа холбооны тасралтгүй, найдвартай байдлыг хангуулах, харьяа байгууллагуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлын нөөц бүрдүүлэх,

**Зургаа. Батлан хамгаалахын сайд,
Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаярт:**

6.1. Болзошгүй үерийн гамшгийн үед дайчилгаагаар ажиллах цэргийн албан хаагчдын болон инженерийн техник, тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх,

6.2. Үерийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн чиглэлээр Барилга, хот байгуулалтын яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,

**Долоо. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:**

7.1. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторк, контент, сурталчилгааны материалууд, сэрэмжлүүлэх мэдээллийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хийх, телевиз, радио, цахим болон үүрэн холбооны сүлжээ, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг ашиглан иргэдэд хүргэх,

7.2. Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Улаан загалмай нийгэмлэг, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр сургалт, нэгдсэн өдөрлөг зохион байгуулах,

7.3. Барилга хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран үерийн аюултай бүсэд суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамгаалах инженерийн болон инженерийн бус арга хэмжээг авах, үерийн эрсдэлтэй газарт зөвшөөрөлгүй суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт зохион байгуулж улсын хяналтын байцаагчийн албан шаардлага нэг бүрчлэн хүргүүлж, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах,

7.4. Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран эргүүл хяналтын ажлыг тогтмол зохион байгуулж, улсын байцаагч нарын албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах,

7.5. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран үерийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх,

7.6. Болзошгүй үерийн гамшгийн үед ажиллах улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас дайчлан ажиллуулах хүн хүч, техник, багаж хэрэгслийн судалгааг бодит байдлаар гаргаж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх,

7.7. Болзошгүй үерийн гамшгийн үед байгууллага хоорондын харилцан ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах шуурхай штабыг ажиллуулах,

7.8. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг нийтэд хүргэх, аюулыг амжиж анхааруулах системийг хөгжүүлэн сайжруулж, хамрах хүрээг өргөтгөх ажлыг шуурхай зохион байгуулах,

7.9. Үерийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуулилтыг эрсдэл бүхий нутаг дэвсгэрт үе шаттай зохион байгуулах,

**Найм. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Сүх-Очирт:**

8.1. Үерийн гамшгийн үед олон нийтийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, авто тээврийн хөдөлгөөн зохицуулалт хийх, үерийн гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх,

8.2. Үерийн гамшгийн үед ажиллах хүн хүч, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх,

**Ес. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Оюунжаргалд:**

9.1. Цаг агаарын болон шар усны үерийн мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллийг өргөн хүрээтэйгээр иргэдэд бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай тогтмол хүргэх, холбогдох байгууллагуудыг мэдээ мэдээллээр тогтмол хангаж, мэдээлэл дамжуулах системийг сайжруулах,

Арав . Ус сувгийн удирдах газарт:

10.1. Үерийн гамшиг тохиолдсон үед иргэдийг ундны усаар хангах төлөвлөлтийг тодотгож, цэвэр усаар хангах зориулалттай байгууламж, ус тээвэрлэх автомашин, зөөврийн ус түгээх цэгүүдийн хэвийн ажиллагааг хангаж, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, эд материал, ариутгалын бодис, шатах тослох материалын нөөцийг бүрдүүлэх,

Арван нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

11.1. Бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хүн, хүч техник хэрэгслийн бодит судалгаанд үндэслэн тодотгол хийх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, тусгайлан үерийн гамшигийн үед дайчлан ажиллуулах хүнд даацын техник, машин механизм, ус соруулах төхөөрөмжүүдийн судалгааг нарийвчлан хийж, бүртгэлжүүлэх, урьдчилсан гэрээ хэлцэл хийж бэлэн байдлыг хангах,

11.2. Суурьшлын бүсийн ойролцоо байдаг гол, нуур, уулархаг газруудад эрсдэлийн үнэлгээ хийх, үерийн эрсдэл бүхий газруудад суурьшсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамгаалах чиглэлээр инженерийн болон инженерийн бус арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авах,

11.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдэд үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, сургалт дадлагын ажлыг шаардлагатай газруудад үе шаттай зохион байгуулах, аюул бүхий газруудыг тэмдэгжүүлэх,

11.4. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг хүргэх, эргүүл хяналт хийх, авран хамгаалах чиглэлээр орон нутгийн Онцгой комисс, шуурхай штаб, мэргэжлийн анги, Онцгой байдлын албанд дутагдалтай байгаа техник, багаж, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг авах,

11.5. Гол, мөрний эрэг, үерээс хамгаалах далан, суваг, шуудуу орчим барилга, хот байгуулалт, цагдаа, онцгой, боловсролын болон хүүхэд хамгааллын байгууллага, улаан загалмай нийгэмлэгтэй хамтран үзлэг шалгалт зохион байгуулах, гарц, урсацыг нээх, шаардлагатай инженерийн болон инженерийн бус арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,

11.6. Үерийн эрсдэл бүхий голын гольдрол, гуу жалга газар эрсдэлийн үнэлгээ хийж, үерт өртөж болзошгүй айл өрх, аж ахуйн нэгжүүдэд аюултай бүсээс нүүн шилжих улсын байцаагчийн албан шаардлагыг нэг бүрчлэн өгч, үерийн гамшгаас учирч болзошгүй хор хохиролыг тайлбарлан таниулж, мэдээлэл сурталчилгаа, заавар зөвлөмжөөр хангаж, аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх,

11.7. Шаардлагатай үед үерийн гамшгаас хамгаалах байгууллага хоорондын харилцан ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий шуурхай штабыг байгуулан ажиллуулах,

11.8. Үерийн гамшиг тохиолдсон үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх газар, түр орогнуулах байруудыг төлөвлөх, бэлтгэх, шаардлагатай ус, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, шатах, тослох материал,

зам, гүүр, далан суваг засварлахад шаардлагатай түүхий эд материалын нөөцийг бэлтгэх, түр орогнох байруудын бэлэн байдлыг хангах,

11.9. Амжиж анхааруулах системийг хөгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, үүрэн холбооны оператор компаниудтай хамран “Багц мессэж” үйлчилгээг ашиглан мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх,


11.10. Голын гольдрол, үер урсаж болзошгүй газруудыг санаатай болон санамсаргүй байдлаар хааж, нарийсгаж боосон газруудыг тогтоож, урсацыг чөлөөлөх арга хэмжээг авах,

11.11. “What3words” байршил тогтоох системийг ашиглан иргэн аж ахуйн нэгж, байгууллага бүрийн байршлыг тогтоох, мэдээлэл дамжуулах,

11.12. Суурьшлын бүсүүдэд үүссэн халиа тошины асуудлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран инженерийн болон инженерийн бус арга хэмжээг төлөвлөн шийдвэрлэж, хор уршгийг арилгах, айл, аж ахуйн нэгжүүдэд хохирол учрахаас сэргийлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг шуурхай авах.

Арван хоёр. Албан даалгаварыг хэрэгжүүлж, тайлагнах:

12.1. Албан даалгаварыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлж, тайланг сар бүрийн эхний 7 хоногт Улсын онцгой комиссын Ажлын албанд албан бичгээр болон uok@nema.gov.mn цахим хаягт цахимаар ирүүлнэ.

ДАРГА  С.АМАРСАЙХАН